

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА,
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ

№	Хаанаас	Саналын утга	Саналыг тусгасан байдал
1.	Монгол Улсын Дээд Шүүх 2021.10.05 5/3986	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр ажиллаж байгаа бөгөөд одоогоор уг хуулийн төсөлд өгөх тусгайлсан саналгүй болохыг үүгээр уламжилж байна.	Тусгайлан саналгүй болно.
2.	Шүүхийн Ерөнхий Зөвлөл 2021.09.27 01/845	Таны 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 1/3909 дүгээр албан бичгээр ирүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцлаа. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах “Гэрч, хохирогч хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Эрүүгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслүүдэд тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.
3.	Төрийн Албаны Зөвлөл 2021.10.15 01/1984	Танаас ирүүлсэн “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг зарчмын хувьд дэмжихийн зэрэгцээ хуулийн төслийг эцэслэн боловсруулахдаа дараах саналуудыг харгалзан үзэхийг хүсье. Үүнд: 1.хуулийн төслийн 4.1.4-ийн “хамаарал бүхий этгээд” ойлголтыг “Гэрч хохирогчийг хамгаалах тухай” болон “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн ойлголтуудтай уялдуулах;	1.Нийтийн албанд албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хамаарал бүхий этгээд нь “...нийтийн албан тушаалтны...” гэж хязгаарласан учир тусгах шаардлагагүй болно.

		2.хуулийн төслийн 5.1.1 дэх заалт “...хууль ёсны...” гэсний дараа “эрх,” гэж нэмэх; 3.хуулийн төслийн “15.2. Дундын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, аюулгүй байдлыг хангах журмыг эрх бүхий байгууллага хамтран батална.” гэсний журам батлах эрх бүхий байгууллагыг тодорхой тусгах эсэх; 4.шүгэл үлээгчийн үйлдэл нь хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-т заасанчлан улсад шууд орлого бий болгоогүй боловч нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй (мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх боломжгүй) нөхцөл байдал, үйлдлээс урьдчилан сэргийлсэн, уг үйлдлийг таслан зогсоосон тохиолдолд олгох мөнгөн урамшууллын асуудлыг тусгаж болох эсэх.	2.Саналыг тусгасан. 3.Саналыг тусгасан. 4.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд уг асуудлыг зохицуулсан байгаа тул тусгах шаардлагагүй болно.
4.	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар 2021.09.21 01/2209	Танаас 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн 1/3909 дугаар албан бичигтэй танилцлаа. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан хамрах хүрээний агуулгатай мөн төслийн 4.1.9-т заасан эрх бүхий байгууллагуудын чиг үүрэгтэй уялдуулан дахин нягтлан үзэж тодруулах. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Эрүүл мэндийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиудын биелэлтэд төрийн хяналт тавих бүрэн эрх хуульчлагдан тусгагдсан бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10-т заасны дагуу уг хуулийн зөрчлүүдэд шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлдэг юм.	1.Саналыг тусгах шаардлагагүй.
5.	Авлигатай Тэмцэх Газар 2021.09.27	Авилгатай тэмцэх газраас боловсруулан хүргүүлсэн Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, бүтэц, үндсэн концепцийг	

	01/9941	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа дэмжин хүлээн авсанд талархаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүдтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна: 1/төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “шүгэл үлээх” гэсэн нэр томъёог тодорхой тайлбарласантай холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх” гэж заавал дурдах шаардлагагүй бөгөөд энэ нь ойлгомжгүй, хоёрдмол утгыг илэрхийлж болзошгүй байгааг харгалзан төслөөс “нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг хасах; 2/төслийн 2 дугаар зүйлийн 2.1-д “...Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хууль,” гэж нэмэх; 3/төслийн 4 дүгээр зүйлд “нийтийн ашиг сонирхол” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг,” гэж нэмэх; 4/төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан “эрх бүхий байгууллага”-д ... Татварын ерөнхий газар хамаарахаар байх тул төслийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх үйл ажиллагаанд тус байгууллагын оролцоог тодорхой тусгах; 5/төслийн 7 дугаар зүйлд 7.4.1-т заасан “энэ хуулийн 6.1.3-т ...”, 9 дүгээр зүйлийн 9.4-т заасан “... энэ хуулийн 11.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ ...” гэсний зүйл, заалтын хувьд тус тус нягтлах; 6/ төслийн 9 дүгээр зүйлийн 9.4-т заасан “... Авилгатай тэмцэх газар, эсхүл шүгэл үлээсэн мэдээллийг шилжүүлж авсан байгууллагаас шаардах эрхтэй.” Гэснийг “...эрх бүхий байгууллагаас шаардах эрхтэй.” гэж өөрчлөх; 7/төслийн 16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсгийг “Мөнгөн шагналын санхүүжилтийн эх үүсвэрийг энэ хуулийн 16.1.1-16.1.2-т заасны дагуу төсөвт орсон хөрөнгө, орлогоос тооцож олгох журмыг Сангийн сайд, Авилгатай тэмцэх газрын дарга хамтран батална.” гэж өөрчлөх	1.Саналыг тусгасан. 2.Саналыг тусгасан. 3.Саналыг тусгах шаардлагагүй. Төслийн 3.1-д нийтийн ашиг сонирхолд хамаарах хүрээг тогтоож өгсөн тул нэр томъёоны тодорхойлолт оруулах шаардлагагүй. 4.Төслийн 14 дүгээр зүйлд эрх бүхий байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгасан. 5.Саналыг тусгасан. 6.Саналыг тусгах шаардлагагүй. 7.Саналыг тусгах шаардлагагүй.
--	---------	--	---

	(Мөнгөн урамшууллын зөвлөл нь эрх бүхий байгууллагын төлөөллөөс бүрдэхээр байх тул төлөөллийн гишүүд хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргуулахгүй байхад анхаарах); 8/ төслийн 7, 8 дугаар зүйлд мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагын талаар тусгасан тул 7.5-д заасан “Эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг бүрдүүлсний дараа өөрийн харьяаллын бус асуудлыг дурдсан мэдээллийг холбогдох байгууллагад шилжүүлэх бөгөөд энэ талаар шүгэл үлээгчид мэдэгдэнэ.” гэснийг хасах; 9/төслийн 15 дугаар зүйлд хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай Дундын мэдээллийн санг хариуцах, хөгжүүлэх, хяналт, мониторинг хийх байгууллагыг тодорхой тусгах, мөн хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Авилгатай тэмцэх газар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн талаарх статистик мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан нийтэд мэдээлэх ба дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлнэ.” гэсэн боловч дээр дурдсан мэдээллийг бусад эрх бүхий байгууллага Авилгатай тэмцэх газарт ямар хэлбэрээр, ямар хугацаанд ирүүлэх талаар тусгаагүй байгааг анхаарах, улсын хэмжээнд аливаа статистик мэдээллийг Үндэсний статистикийн хороо хариуцан гаргадаг тул Авилгатай тэмцэх газар дээрх мэдээллийг нэгтгэн гаргах нь зохимжтой эсэхийг нягтлах; 10/Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг субъект (Авилгын эсрэг хуулийн 4.1 Захиргааны ерөнхий хуулийн 5.1, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажилтан, албан тушаалтан г.м)-ээр тоочиж, төслийн 3 дугаар зүйлийн 3.1-д тусгасан “авилга, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, байгаль орчин,...” зэрэг асуудлаар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх хүрээг төслийн нэр томьёоны тайлбар хэсэгт оруулан тодорхойлох.	8.Саналыг тусгаж, төслийн 7.5 дахь хэсгийг хассан. 9.Төслийн 15.2-т Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нар бусад эрх бүхий байгууллагын саналыг харгалзан хамтран батлахаар тусгасан. 10.Саналыг тусгах шаардлагагүй.
--	---	---

6.	Хуульчдын Холбоо 2021.09.29 1/488	Танаас ирүүлсэн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 1/3911 тоот албан бичигтэй танилцлаа. “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналтай байна: 1.Шүгэл үлээгч нь хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдэлд холбогдох нотлох баримтыг цуглуулах эрх бүхий этгээд мөн эсэх; “нотлох баримт” гэдгийг аль хуульд тусгасан, ямар агуулгаар уг хуульд хэрэглэх; хэрэв ийм баримт байхгүй бол мэдээллийг хүлээн авах эсэхийг эцэслэн тодруулах; 2.Шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг хамгаалах буюу эрх бүхий байгууллагын мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан мэдээллийг бүртгэх, шилжүүлэх үйл ажиллагааны явцад шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох; 3.Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн томъёолол нь шүгэл үлээгчийн шүгэл үлээсний үр дүнд илэрсэн гэмт хэргийн шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх агуулгатай болсон байгаа нь хуулийн төслийн үзэл баримтлал, төсөлтэй уялдахгүй байгааг нягтлах; 4.Мөн Зөрчлийн тухай хуулийн төсөлд тусгасан зөрчлийг үйлдэж болзошгүй субъект нь албан тушаалтан байхаар томъёологдсон нь хууль зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэж байх асуудал Монгол Улс Зөрчлийн тухай хуультай болсноор нэг мөр шийдэгдсэн бөгөөд энэ зарчим Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 21.1 дэх хэсэгт тодорхой тусгагдсан байгаатай нийцэхгүй байгааг анхаарах зэрэг болно. 5.Нийтийн эрх ашгийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай нийцүүлэх, Байгаль орчин гэдгийг “хүрээлэн байгаа	1.Саналыг тусган, өөрчлөн найруулсан. 2.Саналыг тусгах шаардлагагүй. Хувийн мэдээллийг хамгаалах талаар төслийн 5.1.2-т зарчим хэлбэрээр тусгаснаас гадна төслийн 12 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамаарч байгаа болно. 3.Саналыг тусгах шаардлагагүй. 4.Саналыг тусгасан. 5.Саналыг тусгах шаардлагагүй.
----	---	---	--

	орчин”, “Эрүүл мэнд гэдгийг “Нийтийн эрүүл мэнд” гэж тус тус өөрчлөх, “Хүүхдийн эрх”, “Нийтийн өмч” гэдгийг тус тус нэмэх. 6.Хуулийн төсөлд зөвхөн “үйлдэл” хамаарахаар зохицуулсныг өөрчилж “эс үйлдэл”-ийг нэмэх 7.Мэдээллээс гадна “шүгэл үлээгчийг хамгаалах” зарчмыг тусгах 8.Гэрч, хохирогчийг хамгаалж байгаа одоогийн тогтолцоо, хамгаалах байраар явуулахгүй байх, АТГ-ын дэргэд тусгайлсан нэгж байгуулах. Ингэснээр шинээр бий болж байгаа тогтолцоонд итгэх иргэдийн итгэл үнэмшил нэмэгдэнэ. Одоогийн байгаа гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо хангалттай ажилладаггүй, хүрэлцээгүй, тодорхойгүй байдаг тул энэ тогтолцоог дэмжихгүй байна. Судлаачдын судалгаа, дүгнэлтээр ч энэ тогтолцоонд асуудал байгааг гаргаж ирдэг. 9.Албан тушаалтны зөвхөн “давуу байдал” бий болгосон үйлдлийг зохицуулсныг өөрчлөх, “ашиг хонжоо”, “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” үйлдлийг зайлшгүй оруулах. Авилгатай тэмцэх тухай хуультай нийцүүлэх. 10.Юуны өмнө мэдээлэл өгөхөд хялбар, хүнд сурталгүй, мэдээлэл өгсөн хүнийг өөрийг нь шалгаадаг, асуудаг одоогийн нөхцөл байдлыг таслан зогсоох. Тиймээс “шүгэл үлээгч”-ийн РД, овог нэр зэрэг мэдээллийг хамгийн түрүүнд шаардахгүй байх. Одоогийн мэдээлэл хүлээн авдаг тогтолцооноос 108 утас болон ФБ пэйж хамгийн түргэн шуурхай мэдээлэл авдаг, харьцангуй хүнд суртал багатай байдаг. Хэрэв шүгэл үлээгч хожим урамшуулал авах сонирхолтой бол энэ талаар мэдээллийг дараагийн шатанд авах. 11.Мэдээллээ хуульчаас гадна сэтгүүлчээр дамжуулан мэдээлдэг болдог байх. Хэвлэл мэдээллийн байгууллага, хуульч аль аль нь	6.Төслийн холбогдох заалтуудад “үйлдэл, эс үйлдэхүй” гэсэн агуулгаар тусгасан байгаа. 7.Төслийн 12 дугаар зүйлд хамгаалалтын арга хэмжээний талаар зохицуулсан байгаа. Түүнчлэн энэ хуулийн зорилго нь бүхэлдээ шүгэл үлээгчийг хамгаалах тул зарчим болгож оруулах шаардлагагүй. 8.Төслийн 7.7-д саналыг тусгасан. 9.Саналыг тусгасан. 10.Саналыг тусгасан. 11.Төслийн 9.9-д заасны дагуу шүгэл үлээгч эрх
--	---	---

		тусгайлан “нууц хадгалах” дүрэм, журамтай, тогтолцоотой, харьцангуй энэ механизм нь ажилладаг, туршигдсан. 12.Шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авдаг нэг сувагтай байх. Шүгэл үлээгч өөрөө энэ чиглэлийн мэдээлэл учраас энэ байгууллагад гэж ангилах, эрх зүйн мэдлэг хомс, мэдээлэл хүлээн авагч байгууллагууд нь нэн даруй, яаралтай үед 24 цаг ажиллах эсэх нь тодорхойгүй тул /ХЭҮК, ТЕГ зэрэг/ нэгдсэн нэг суваг, утас, цахим сүлжээ байх боломжийг бий болгох. Мэдээллийг хүлээн авагч нь ангилах, зохих байгууллагад нь мэдээлэх, бүртгэх ажлыг гүйцэтгэдэг байх. 13.Шүгэл үлээгчээс өөрөөс нь /5 хоногийн дотор/ нийтийн ашиг сонирхлын мөн үү, биш үү гэж үзэх үндэслэл, зорилгыг асуух нь эргээд мэдээлэл өгсөн хүнээсээ мэдүүлэг авдаг, шалгадаг нөхцөлийг бүрдүүлж болзошгүй юм. Энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан үндэслэлийг энд дахин дурдъя. “Харин албан тушаалтантай холбоотой” авлигын асуудлыг шалгахаасаа илүү авлигын мэдээллийг хэн өгч байгааг шалгах” тохиолдол байна. Тиймээс энэ хэсгийг хасах 14.Хуулийн 8.3.2 өмнө нь шалгуулж, үр дүнг нь мэдэгдсэн асуудлаар дахин шүгэл үлээсэн; гэдгийг дахин хянах. Тухайлбал, НӨАТ-ын баримтыг холбогдох байгууллагууд өгдөггүй талаар иргэн Б-ээс нийт 73 удаа гомдол мэдүүлдэг. Үүнд нэг ижил байгууллага, нэг асуудлаар хэд хэдэн удаа хандсан тохиолдол ч байдаг. Эцэст НӨАТ-ын төлөлтийг сайжруулах, хаанаа ямар алдаа, асуудал байгаа талаар ТЕГ-аас түүнд хариу ирүүлсэн. Энэ асуудал одоо ч бүрэн шийдэгдээгүй байдаг. Энэ тохиолдолд хуулийн дээрх зохицуулалтад орж байна.	бүхий байгууллагад мэдээлэл өгсөн асуудлаар нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болохоор заасан. 12.Төслийн 7.5-д саналыг тусгасан. 13.Саналыг тусгасан. 14.Саналыг тусгах шаардлагагүй.
7.	Монголын өмгөөлөгчдийн холбоо 2021.09.24 01/1349	1.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Хуулийн зорилт” гэснийг “хуулийн зорилго” гэж өөрчлөх. Тайлбар:Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг тусгаж	1.Саналыг тусгах шаардлагагүй.

	өгсөн бөгөөд 29.1.11-д “хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана” гэж заасан. 2.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “шударгаар татвараа төлөх” гэсний дараа “нийтийн өмчийг хамгаалах” гэж нэмэх. Тайлбар:Хуулийн үйлчлэх хүрээ нь зөвхөн тухайлсан харилцааг зохицуулна гэж байгаа бол дурдагдаж буй асуудлыг нэмж оруулах. 3.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “шүгэл үлээгч” гэж нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, өргөдөл, гомдол гаргах, тайлбар өгөх /цаашид “мэдээлэл өгөх” гэх/-ийг гэж өөрчлөх Тайлбар:Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т “Эс үйлдэхүй гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага хуульд заасан хугацаанд биелүүлээгүй, эсхүл шийдвэрлэхгүй орхигдуулсныг ойлгоно” гэж зааснаас үзвэл аливаа этгээд эс үйлдэхүй гаргасны улмаас нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол түүнийг мэдээлэх нь хуулийн төслийн зорилтод нийцэхээр байна. 4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “шууд орлого” шүгэл үлээсний үр дүнд улсын төсөвт шууд хэлбэрээр оруулсан орлогыг гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.1-т Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх” гэж заасны дагуу нийцүүлэх. 5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дахь хэсэгт “...9 дүгээр зүйл” гэснийг “9 дүгээр зүйлд” гэж өөрчлөх. 6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь хэсэгт “сувгийг” гэдгийг хасч “үйл ажиллагааг” гэж өөрчлөн найруулах, 5.1.4 “хүртээмжтэй, найдвартай үйл ажиллагааг бий болгох” Тайлбар:Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т хуулийн төслийн хэл зүй, найруулна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд ойлгоход хялбараар бичих ” гэж заасан. Тус зарчимд заасан “суваг ” гэдэг үг нь ойлгомжгүй, тодорхой биш байна.	2.Саналыг тусгах шаардлагагүй. 3.Саналыг тусгасан. 4.Саналыг тусгаж, өөрчлөн найруулсан. 5.Саналыг тусгасан. 6.Саналыг тусгах шаардлагагүй.
--	---	--

	7.Төслийн 5.1.5 дахь хэсгийн “нийтийн ашиг сонирхлын төлөө оруулж байгаа шүгэл үлээгчийн хувь нэмрийг цаг алдалгүй үнэлэх урамшуулах” гэж заасныг бүхэлд нь хасах саналтай байна. Тайлбар: Зарчим нь хуулийг хэрэгжүүлэхэд гол баримтлал, мөрдлөг тул Хуулийн төслийн 16 дугаар зүйлд “Шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгох” тухай зохицуулсан тул зарчим болгож оруулах шаардлагагүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; гэж заасан. Уг зарчмын агуулга нь хэт нуршуу байхаас гадна хуулийн төсөлд шүгэл үлээгчийн хувь нэмрийг үнэлэх талаар ойлголт, зохицуулалт байхгүй. 8.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож бичгээр болон амаар мэдээлэл гаргана. Мэдээллийг эрх бүхий байгууллагын цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно.” гэж өөрчлөн найруулах Тайлбар:Хуулийн төслийн 7.2-д эрх бүхий байгууллага нь Улсын ерөнхий прокурорын газар, Авилгатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар байна” гэж тодорхойлсон байна. Уг байгууллагуудад мэдээлэл гаргахад Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг шаардлага тавигдах тул тус хуулийн зохицуулалттай нийцүүлэх нь зүйтэй байна. 9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1-т “..эс үйлдэхүй, үйлдэл” гэснийг “үйлдэл, эс үйлдэхүй” болгох, “хийсэн” гэснийг “гаргаж буй” болгох. 10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргаж буй талаарх үндэслэл бүхий тайлбар, түүнд холбогдох нотлох баримт” гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Шүгэл үлээгч нь мэдээллийнхээ эх сурвалжийг үнэн, зөв заах, үндэслэл бүхий тайлбар гаргах нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, худал мэдээллээ тараахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. 11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан “Шүгэл үлээгчийн амаар гаргасан мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан тэмдэглэл	7.Уг заалтыг өөрчлөн найруулсан. 8.Саналыг тусгах шаардлагагүй. 9.Саналыг тусгасан. 10.Саналыг тусгах шаардлагагүй. 11.Саналыг тусгах шаардлагагүй.
--	---	--

	хөтөлж, тэмдэглэлд мэдээлэл өгсөн хүний гарын үсгийг зуруулна. Амаар гаргасан мэдээлэлд энэ хуулийн 6.2.2-т заасан нотлох баримтыг гаргаж өгнө” гэж өөрчлөн найруулах. Тайлбар Төслийн 6.1-т оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор уг заалтыг ойлгомжтой болгох шаардлагатай. 12.Төслийн 7 дугаар зүйлийн 7.4.1-т “энэ хуулийн 6.1.3-т заасан мэдээллийг ирүүлээгүй бол тодруулах” гэснийг хасах 13.Төслийн 7 дугаар зүйлийн 7.5-т “Шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авсан байгууллага энэ хуулийн 6.2-д заасан мэдээллийг тодруулсны дараа өөрийн эрх хэмжээнд хамаарахгүй асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагад даруй шилжүүлэх бөгөөд энэ талаар шүгэл үлээгчид мэдэгдэнэ” гэж өөрчлөн найруулах; 14.Төслийн 8 дугаар зүйлийг “..явуулахгүй байх үндэслэл” гэснийг “...явуулж болохгүй тохиолдол” гэж өөрчлөн найруулах. 15.Төслийг 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсэгт “төслийн 4.1.1-т заасан нэр томьёоны өөрчлөлттэй холбоотой 8.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах; 16.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т “..мэдээлэлд” гэсний дараа “30 хоногийн дотор” гэж нэмэх; Тайлбар:Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ” гэж заасан. Уг хуулийн төрийн байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэх ерөнхий хугацааг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.Хуулийн төсөлд мэдээллийг хэд хоногт хяналт, шалгалт явуулан шалгах талаар тусгагдаагүй байгаа нь мэдээллийг урт хугацаанд шалгахгүй орхих, нийтийн ашиг сонирхлыг хохироод өнгөрсөн хойно нь арга хэмжээ авч, мэдээллийг ач холбогдолгүй болгох нөхцөлийг бүрдүүлэхээр байна; 17.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3.1-т илт худал мэдээллээр шүгэл үлээсэн гэснийг өөрчлөх эсхүл хасах; Тайлбар:Хуулийн төслийн 8.1, 8.2-т эрх бүхий байгууллага хяналт, шалгалтын ажлыг явуулсны үндсэн дээр мэдээллийн зөвийг тогтоохоор зохицуулсан байна. Гэтэл ямар ч хяналт, шалгалт	12.Саналыг тусгах шаардлагагүй. 13.Саналыг тусгасан. 14.Томьёоллыг хэвээр үлдээсэн. 15.Саналыг тусгасан. 16.Төслийн 8.2-т саналыг нэмж тусгасан. 17.Саналыг тусгах шаардлагагүй.
--	---	--

	явуулаагүй атал шууд “илт худал мэдээллээр шүгэл үлээсэн” гэж хэн, хэрхэн тогтоож байгаа нь тодорхойгүйгээр мэдээллийг хүлээн авахаас татгалзаж байгаа нь ойлгомжгүй, тодорхойгүй хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1-т хуулийн төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна. 29.1.5 зүйл, хэсэг заалт нь хоорондоо зөрчилгүй байх; гэж заасан шаардлагыг хангахгүй байна. 18.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэгт “... асуудлаар” гэсний дараа “дахин” гэж нэмэх; 19.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дахь хэсэгт “... эс үйлдэл, үйлдлийг” гэснийг “үйлдэл,эс үйлдэхүй” гэж өөрчлөх; Тайлбар:Төслийн 4.1.1-т заасан нэр томъёоны өөрчлөлттэй холбоотой 8.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах; 20.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дахь хэсгийн “Эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 8.3-т заасан үндэслэл байгаа тохиолдолд энэ талаар шүгэл үлээгчид бичгээр мэдэгдэнэ” гэж өөрчлөх; Тайлбар: ойлгомжтой, тодорхой байдлаар найруулах 21.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 “...бусдын”, “..түүнд” гэснийг хасах; 22.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт Энэ хуульд 6.1.6 гэсэн заалт байхгүй.Зохих заалтыг оруулах; 23.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийг “Шүгэл үлээгч энэ хуулийн 9.5-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргана” гэж өөрчлөн, найруулах; Тайлбар:Төслийн 14.1.6-д “шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах” гэж хүсэлтийн дагуу ямар арга хэмжээ авах талаар зохицуулалт оруулах шаардлагагүй; 24.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг хасах саналтай; Тайлбар Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т Хуулийн төслийн агуулга дараах нийтлэг хангасан байна: 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;” гэж заасантай нийцэхгүй байна. 25.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэгт “<u>үндэслэлгүйгээр</u> цалин хөлсийг бууруулах..” гэж нэмж найруулах.	18.Саналыг тусгасан. 19.Уг хэсгийг өөрлөн найруулсан. 20.Саналыг тусгаж, томъёоллыг өөрчилсөн. 21.Томъёоллыг хэвээр үлдээсэн. 22.Саналыг тусгасан. 23.Томъёоллыг хэвээр үлдээсэн. 24.Саналыг тусгах шаардлагагүй. 25.Саналыг тусгасан.
--	---	--

	26.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дахь хэсэгт Мэдээллийг хянан шалгах явцад дараах нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу мэдээллийг шалгаруулахаар холбогдох эрх бүхий байгууллагад нотлох баримтын хамт шилжүүлнэ” гэж өөрчлөн, найруулах; Төслийн 11.4.1-11.4.2-т заасан үйлдэл нь гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй байх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу шалгаж, тогтоогдох тул төсөлд заасан хяналт, шалгалтын ажиллагааны явцад эдгээр нь илэрч байгаа тохиолдолд харьяаллын дагуу шилжүүлэхээр зохицуулах нь хууль тогтоомжид нийцэхээр байна. 27.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.2 дахь хэсэгт “өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал бий болгох зорилгоор шүгэл үлээсэн”, 11.4.3.“хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан”, гэж 2 зүйл болгож, салгах; 28.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Шүгэл үлээгч нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйн талаар байгууллага дотроо шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах арга хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу авна. Тайлбар:Төслийн 4.1.1-т заасан нэр томьёоны өөрчлөлттэй холбоотой тус хэсгийг өөрчлөн найруулах 29.Төслийн 12 дугаар зүйлийн 12.4–т “Шүгэл үлээгчийг байгууллагын хэмжээнд дэмжих, хамгаалах арга хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгана” гэх заалт нэмэх Тайлбар:Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу байгууллагын хэмжээнд шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл байдлыг халах зорилгоор тухайлан үүрэг болгосон зохицуулалт оруулах шаардлагатай. 30.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2-т Дундын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, аюулгүй байдлыг хангах журмыг..... хамтран батална” гэж тухайлан нэрлэн зааж оруулах Тайлбар:Хуулийн төслийн 7.2-д Эрх бүхий байгууллага нь Улсын ерөнхий прокурорын газар,Авилгатай тэмцэх газар, Хүний эрхийн	26.Саналыг тусгах шаардлагагүй. 27.Саналыг тусгах шаардлагагүй. 28.Томьёоллыг хэвээр үлдээсэн. 29.Төслийн 12.3-т энэ агуулгыг дурдсан тул нэмж тусгах шаардлагагүй. 30.Төслийн 15.2-г өөрчлөн найруулсан.
--	---	--

	Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар байна” гэж заасан байгууллагуудын яг хэн нь хамтарч батлах талаар шууд нэрлэн зааж бичих нь зүйтэй. 31.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1-д “улсад шууд орлого бий болгосон” гэснийг хасах Тайлбар:Шүгэл үлээгч заавал орлого бий болгох асуудлаар шүгэл үлээвэл урамшуулал олгоно гэж ойлгогдохоор байна. Иймээс “улсад шууд орлого бий болгосон” гэснийг хасах Тайлбар:Шүгэл үлээгч заавал орлого бий болгох асуудлаар шүгэл үлээвэл урамшуулал олгоно гэж ойлгогдохоор байна. Иймээс “улсад шууд орлого бий болгосон” гэснийг хасах 32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.4.1-д тавин саяас хоёр зуун тавин сая хүртэл төгрөгийн орлогод 10 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 14 хувийг нэмнэ; гэж найруулах; Мөн төслийн 16 дугаар зүйлийн 16.4.3-т хоёр зуун тавин саяас нэг тэрбум хүртэл төгрөгийн орлогод 36 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг нэмнэ; гэж найруулах. 33.Төслийн 16 дугаар зүйлийн 16.4.4 нэг тэрбумаас хоёр тэрбум хүртэл төгрөгийн орлогод 113 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг нэмнэ; гэж найруулах. 34.Төслийн 16 дугаар зүйлийн 16.4.5. хоёр тэрбум ба түүнээс дээш төгрөгийн орлогод 173 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ гэж найруулах. 35. Төслийн 16 дугаар зүйлийн 16.6-т дахь хэсгийг хасах Тайлбар:Хуулийн төслийн 16.1-д шүгэл үлээгч мөнгө урамшуулал авах тухай зохицуулалтыг тусгаж 16.4-д урамшууллын хэмжээг багасгаж тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал,хөрөнгө чинээ,эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасантай нийцэхгүй байна.	31.Саналыг тусгасан. 32.Саналыг тусгах шаардлагагүй. 33.Саналыг тусгах шаардлагагүй. 34. Саналыг тусгах шаардлагагүй. 35. Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллийг мэдээллэх үүргийг хуулиар хүлээсэн, төсвөөс цалинждаг албан тушаалтан тул ялгавартай тогтоогоогүй болно.
--	---	--

8.	Транспэрэнси Интернэшнл-Монгол 2021.09.21 2/123	Танаас ирүүлсэн 9 дүгээр сарын 9-ний өдрийн 1/3911 тоот албан бичгээр ирүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төсөлд манай байгууллагын баримталдаг зарчим болон олон улсын сайн туршлага дээр үндэслэн дараах зүйлийг тусгах саналтай байна.Үүнд: 1.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих, шударгаар татвараа төлөх” гэж тусгасан байгаа нь хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлаж байна. Иймд уг заалтад “Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журам, олон улсын гэрээг зөрчсөн талаар шүгэл үлээсэн этгээдийн..” гэж нэмэх, 2.Дийлэнх шүгэл үлээгчид мэдээлэл өгөхдөө эхэлж өөрийн ажлын байрны дотоод мэдээлэх сувгийг ашиглан шүгэл үлээдэг. Ажил олгогч нь байгууллага дотроо шүгэл үлээгчийн мэдээлэлтэй харьцах, шийдвэрлэх бололцоо өндөр. Иймд хувийн болон улсын байгууллагуудад дотоод мэдээлэх суваг шаардлагатай байдаг. Жишээлбэл Франц, Нидерланд, Словак улсуудад 50 болон түүнээс дээш албан хаагчтай аж ахуйн нэгж шүгэл үлээх дотоод сувагтай байхыг хуулиар шаарддаг. Иймд “Байгууллагын хариуцлага” гэсэн зүйл нэмж түүнд байгууллага дотроо шүгэл үлээх суваг бий болгох, нөхцөл бүрдүүлэх тухай нарийн тусгах, 3.Эрх бүхий байгууллага хандаад үр дүн гараагүй эсхүл шүгэл үлээгчид нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ, хуулийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, эсхүл мэргэжлийн байгууллагуудад хандаж болох талаар заалт оруулах зэрэг саналтай байна.	1.Саналыг тусгах шаардлагагүй. 2.Саналыг тусгах шаардлагагүй. 3.Саналыг тусгах шаардлагагүй.